

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС

МЭДЭЭ

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг зохион
байгуулсан ажлын тухай

2019 оны 09 дүгээр сарын 30

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь 2019 оны гуравдугаар улиралд өргөдөл гомдол шийдвэрлэлтийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамж, холбогдох эрх зүйн актын хүрээнд зохион байгуулан ажиллалаа.

Нэг. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээ

Манай байгууллага нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д нийцүүлэн ажилтан, албан хаагчид, иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг тухай бүр бүртгэлийн системд байршуулан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг хуанлийн 10 хоног тутам хөтлөн ажиллаж байна.

Иргэд, аж ахуйн нэгжүүд болон ажилтан, албан хаагчдаас тайлант хугацаанд нийт 58 өргөдөл ирсэнээс 55 /94,83%/ өргөдлийн хариуг өгсөн, шийдвэрлэгдэх шатанд буюу хугацаа болоогүй 3 (5,17%) өргөдөл байна. Тайлант хугацаанд өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчилгүй, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 1 зөрчил бүртгэгдсэн.

Хоёр. Өргөдөл, гомдлын хандалтын мэдээ

Байгууллагад ирсэн өргөдөл гомдлыг хандалтын төрлөөр нь ангилвал:

- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл, хүсэлт – 15;
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл, хүсэлт – 15;
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл, хүсэлт – 16;
- Жирэмсний болон ээлжийн амралт хүссэн өргөдөл, хүсэлт – 6;
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл, хүсэлт – 6;

Өргөдөл гомдлын төрлийг нийт өргөдөлд эзэлж буй хувиар нь үзүүлбэл:




График 1: Өргөдөл гомдлыг нийт өргөдөлд эзэлж буй хувиар нь ангилсан байдал

Гурав. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх үетэй харьцуулсан байдал


Д/д	Хугацаа	2018.03 улирал	2018.04 улирал	2019.01 улирал	2019.02 улирал	2019.03 улирал
Ерөнхий үзүүлэлт						
1	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	4 хоног 20 цаг 05 минут	4 хоног 11 цаг 25 минут	5 хоног 7 цаг 30 минут	4 хоног 4 цаг 42 минут	5 хоног 4 цаг 51 минут
2	Хандалтын тоо	63	52	31	60	58
3	Зөрчлийн үзүүлэлт	0	0	0	1	1
Өргөдөл, гомдлын хандалтын төрөл						
4	Хөдөлмөрийн хөлсний тухай	5	8	3	19	15
5	Захиргааны чөлөө хүсэх тухай	18	13	6	18	15
6	Ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх тухай	22	15	11	12	16
7	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	2	4	1	-	-
8	Жирэмсний болон ээлжийн амралтын тухай	5	8	5	5	6
9	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	6	9	5	6	6
10	Ажлын сахилга хариуцлагын тухай	4	1	-	-	-
11	Бусад асуудлаар	1	1	-	-	-

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН



Т.ИТГЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
ХАРИУЦСАН АЖИЛТАН



Э.ХОРОЛДУЛАМ